



# СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№42 /486/

2023.03.10

Цаг үе, үйл явдал

## МОНГОЛ УЛСЫН АНХНЫ ЭМЭГТЭЙ ГЕНЕРАЛ Г.БОЛОР ОЛОН УЛСЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭР ЗОРИГИЙН ШАГНАЛЫГ ГАРДАН АВЛАА



Монгол Улсын ЗХЖШ-ын Сургалт, бэлтгэлийн газрын дарга бригадын генерал Г.Болор АНУ-ын Цагаан ордонд жил бүр олгодог Олон улсын эмэгтэйчүүдийн эр зоригийн шагналыг

гардан авлаа. Шагналыг АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Антони Ж.Блинкен болон Тэргүүн хатагтай Жилл Байден нар гардуулжээ. 2023 оны Эр зоригийн шагналыг дэлхийн өнцөг булан бүрээс

шалгарсан нийгмийн гэрэлт ирээдүйг цогцлоохын төлөө ажиллаж буй "онцгой" гэсэн тодотголтой 11 эмэгтэйд олгосон байна.



### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-3	-18

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
38	27

### ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,529	3,534
EUR	3,755	3,770
CNY	507.50	509.50
RUB	45.10	45.50
JPY	26	26.30
KRW	2.70	2.72

### ЗУРХАЙ

2023.03.10 /БААСАН ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 18

ХАВРЫН ТЭРГҮҮН ХӨХ БАР САР НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ УЛААГЧИН ТУУЛАЙ ӨДӨР

ҮС ЗАСУУЛБАЛ:

Эд малын гарлагатай НАРАН УРГАХ, ШИНГЭХ: 07.16-18.49

Барилдлага:

Үл тохирох ШҮТЭН БАРИЛДЛАГА: Өтлөх үхэхүй

## “ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЭ” ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНИЙ АЯНД БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАР НЭГДЭЖ БАЙНА



Schweizerische Eidgenossenschaft Confédération suisse Confederazione Svizzera Confederaziun svizra

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРОО

НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр Жендерийн Үндэсний Хороо, ЖҮХ-ны Салбар зөвлөл, Салбар хороод, хүний эрх, жендерийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ, иргэний нийгмийн байгууллагууд, Олон улсын байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж байгаа “Харилцан хүндэтгэе” аянд Батлан хамгаалах салбар нэгдэж байна.

Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.10 дахь хэсэгт заасан Жендерийн эрх тэгш байдлыг хангах төрийн бодлого, хууль тогтоомжийг аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтэд таниулах, сурталчлах үйл ажиллагааг хэвлэл мэдээлэл, олон нийтийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран зохион байгуулах, жендерийн эрх тэгш байдлыг хангах ажлын үр дүнгийн тухай мэдээлэх чиг үүргийнхээ хүрээнд Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан Батлан хамгаалах салбар тус аянд нэгдэж байгаа юм.

Энэ удаагийн “Харилцан хүндэтгэе” аяныг “Надаас, Танаас, Биднээс Эхлэлтэй” уриатайгаар зохион байгуулж байгаа бөгөөд харилцан хүндэтгэлтэй байя, эмэгтэйчүүдийн нийгэмд үзүүлэх үр нөлөө, эмэгтэйчүүдийн

манлайлал болон өсвөр насны үеийн жендерийн талаарх ойлголт мэдээллийг нэмэгдүүлэх, цахим орчинд ялгаварлан гадуурхалтыг багасгах зорилготойгоор зохион байгуулж буйгаараа онцлогтой юм.

Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 4.1.2 дэх хэсэгт “жендерийн эрх тэгш байдал” гэж эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаа жендерийн ялгаварлан гадуурхалтаас анги байхыг хэлнэ хэмээн заасан байдаг.

Өнгөрсөн хугацаанд уг аянаар зөвхөн нэг хүйсэд чиглэсэн олон талт арга хэмжээ зохион байгуулж байсан бол энэ жилийн хуви жендерийн мэдрэмжтэй байх үүднээс Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр Монгол цэргийн өдрийг тус тусад нь бус хамт нь нэгтгэж, аян зохион байгуулж байна.

Аяны хүрээнд дараах үр дүнд хүрэх төлөвлөсөн юм.

Үүнд: 1. Жендерийн талаарх олон нийтийн ойлго мэдлэгийг нэмэгдүүлэх, өргөжүүлэх. 2. Нийслэлийн охид хөвгүүдийн зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлснээр ахл

ангийн сурагчдыг жендерийн мэдрэмжтэй иргэн болгон төлөвшүүлэх.

3. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс хамтдаа тэгш боломж тэгш харилцаатай ажиллаж амьдрах эерэг хандлагыг нийгэмд бий болгох.

4. Төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг зохиц түүвшинд өргөжүүлэх.

5. Олон нийтийн үүрэг оролцоог нэмэгдүүлж, нөлөөллийн ажлыг зохион байгуулах.

6. Жендерийн хэвшмэл буруу ойлголтыг арилгах.



### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 681,212,510

Эдгэрсэн

Нийт: 654,132,455

Нас барсан

Нийт: 6,809,882

Цахим шууданд

БНӨСУ-ААС МЭДЭЭЛЖ БАЙНА

# ЭНХИЙГ САХИУЛАГЧИД ХАЙРТАЙ ЭЭЖҮҮДДЭЭ ЗАХИДАЛ ХҮРГҮҮЛЖЭЭ



Олон улсын захидал шилдгээр шалгарч эмэгтэйчүүдийн эрхийг ахлагч Б.Нямсүх, ахлагч хамгаалах өдрийг О.Отгонбилэгийн захидлууд тохиолдуулан эх үрийн нандин холбоо, гэр бүлийн үнэ цэнийг сурталчлах, сайхан сэтгэлийн үгээр ээждээ ухаарал, уучлалаа илэрхийлж сэтгэлийн бэлэг барих боломжийг олгох зорилгоор батальоны бие бүрэлдэхүүний дунд "Ижийдээ захидал бичээрэй" уралдааныг зохион байгууллаа.

Уралдаанд Завхан Уг уралдаан нь өдөр аймгийн Их-Уул суманд тутам хэлдэггүй ч өнө мөнхөд оршин суугаа ээж Р.Цэнд-Аюушдаа зориулан бичсэн ахлагч Б.Пүрэвпэлжээгийн олгосон юм.

# УДИРДАХ БҮРЭЛДЭХҮҮНИЙ НӨХӨРСӨГ ТЭМЦЭЭН ЭХЭЛЛЭЭ



"Монгол цэргийн өдөр", орчин цагийн Зэвсэгт хүчин 102 жилийн ойг тохиолдуулан төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын удирдлагуудын дунд уламжлал болгон зохион байгуулагддаг "Бидний нөхөрлөл" цогцолбор тэмцээн энэ сарын 8-ны өдрөөс эхэллээ.

Энэ нь төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын удирдлагуудын нэгдмэл үйл ажиллагаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх, нөхөрсөг уур амьсгалыг бүрдүүлэх, бие бялдрын бэлтгэлжилт, бэлэн байдлыг дээшлүүлэх зорилготой бөгөөд энэ жил хуваарийн дагуу Хил хамгаалах Ерөнхий газраас зохион байгуулж байна.

Цогцолбор тэмцээнд БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлалууд, удирдах газар, ХХЕГ, ОБЕГ, ЦЕГ, Дотоодын цэргийн штаб, Тагнуулын Ерөнхий газар, ШШГЕГ, ТТХГ зэрэг 14 байгууллагын 13 багийн 100 гаруй удирдах бүрэлдэхүүн "Буудлага", "Биллиард", "Волейбол" гэсэн гурван төрлөөр өрсөлдөж байна. Биллиардын тэмцээн 3 дугаар сарын 8-ны өдөр явагдаж тэргүүн байрт ХХЕГ, дэд байрт ЗХЖШ, гутгаар байрт Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын удирдлагууд шалгарсан бол өнөөдөр буудлагын тэмцээн зохион байгуулагдаж, маргааш волейболын тоглолтоор үргэлжилнэ. **Хошууч З.БАТ-ОРГИЛ**

# ЭНХИЙГ САХИУЛАГЧИД МОНГОЛ ӨВ СОЁЛ, ЗАН ЗАНШЛАА СУРТЧИЛЛАА



Билгийн тооллын XVII жарны "Үзэсгэлэн болгогч" хэмээх харагчин Усан туулай жилийн сар шинийн баярыг тохиолдуулан монгол түмний үндэсний өв соёл, дуу хуур, тоглоом наадгай, түүх шастир, зан заншлаар монгол хүн бүр бахархаж, үндэсний урлаг, соёл, ардын уламжлалт ёс заншлыг өвлөн тээгч байхыг батальоны бие бүрэлдэхүүнд сурталчлан таниулах зорилготой тэмцээн уралдаануудыг зохион байгууллаа.

Энхийг сахиулагчид маань батальоны бие бүрэлдэхүүний дунд зохион байгуулсан уралдаан тэмцээнд амжилттай

оролцсоноос гадна БНӨСУ-ын Юнити мужын Бентью, Париан, Зүүн секторын Бор сууринд байрлаж буй НҮБ-ын баазад үүрэг гүйцэтгэж буй 30 гаруй орны штабын болон ажиглагч офицерууд, энгийн ажилтнуудад зориулсан сар шинийн баярын хүндэтгэлийн тоглолт, үндэсний бөх, сурь харвааны үзүүлэх тоглолтыг зохион байгуулж, Монголын төрт ёсны уламжлалт их баярын онцлог, монгол ахуй, үндэсний өв соёл, түүхэн уламжлал, ёс заншил болон Монгол Улс, монгол цэрэг, цэргийн багийн үйл ажиллагааг сурталчилсан юм.

**АХМАД О.ИЧИННОРОВ**



# "СЭТГЭЛ НЭГТ" УРИАН ДОР "УРМЫН ТОЙРГО"-ООР АЯЛАЛАА



Зэвсэгт хүчин 2023 оныг Залуусын манлайллын жил болгон зарласантай холбогдуулан Зэвсэгт хүчний 340 дүгээр ангийн эмэгтэй алба хаагчид "Манлайлалд эмэгтэйчүүд бидний оролцоо" сэдэвт чуулга уулзалтыг энэ сарын 7-ны өдөр зохион байгууллаа.

Чуулга уулзалтаар эмэгтэй алба хаагчдын тэгш оролцоог нэмэгдүүлэх, манлайлалд эмэгтэйчүүдийн оролцоог дээшлүүлэх, эмэгтэй алба хаагчдын сэтгэл зүйн тогтвортой байдалд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх, хамт олны дунд нөхөрсөг харилцааг бий болгохыг зорилоо.

Чуулга уулзалтыг нээж сэтгэл зүйн хангалтын офицер дэслэгч Д.Уянгаа "Манлайлалд эмэгтэйчүүд бидний оролцоо", "Монгол эмэгтэйчүүдийн сэтгэл зүйн онцлог" сэдвээр илтгэл тавьж, хэлэлцүүлгийг зохион байгуулсны зэрэгцээ эмэгтэй алба хаагчдад өөрсдийн сэтгэл хөдлөл, хувийн онцлогоо таньж мэдэхэд туслах "EQ" картаар бүлгийн дасгалыг зохион байгуулж, урлагийн сэтгэл заслын нэг төрөл "Мандала"-г будаж стресс ядаргаагаа тайлахад тусалцаа үзүүлээ.

Мөн энэ үеэр алба хаагчдын хувийн онцлогийг таньж мэдэх "Геометрийн дүрсээр хүн зурах" тест, "Өнгө ба зан авир", "Сэтгэл геометрийн тест", "Таны амьдралын зам", "Хөрөг зургийн тест" зэрэг 20 гаруй аргаар сэтгэл зүйн оношилгоо хийж холбогдох заавар, зөвлөгөөг алба хаагчдад өглөө.

Чуулга уулзалтад оролцсон эмэгтэй алба хаагчид "Сэтгэл нэгт" уриан дор "Урмын тойрго"-оор аялж бие биедээ удаан бодож явсан сэтгэлийн үгээ баярын нулимстай илэрхийлж байсны зэрэгцээ мэндчилгээ, сэтгэлийн үгээ "Сэтгэл нэгт" талархлын самбарт бичин үлдээж байлаа.

Уг чуулга уулзалтын төгсгөлд алба хаагчид нээлттэй индэрт гарч өөрсдийн санал хүсэлтээ илэрхийлсэн бөгөөд дараах зүйлсийг ойрын хугацаанд болон цаашдын ажилд мөрдлөг болгон ажиллахыг удирдлагуудад уламжилсан юм.

Ташрамд дуулгахад тус үйл ажиллагааг хүндэтгэн алба хаагчид үндэсний хувцсаараа гоёж, түүнчлэн эмэгтэйчүүдийн зүгээс хугацаат цэргийн алба хаагчдад заавал сурах нийтийн цэнгээнт 10 бүжгээс "Задгай цагаан", "Хүмүүн төрөлхтөн", "Гурван тамирын уянга" бүжгүүдийг зааж сургалаа.

**Дэслэгч Д.УЯНГАА**

# МӨРДЭСТЭЙ БҮСГҮЙЧҮҮД ӨРСӨЛДЛӨӨ



Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабаас Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын эмэгтэй алба хаагчдын ажил хөдөлмөрийг сурталчлах, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор "Мөрдөстэй бүсгүйчүүд" уралдааныг зохион байгууллаа.

Энэ жилийн тэмцээнд Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын 30 гаруй эмэгтэй алба

хаагч оролцож багийн мэндчилгээ, гэрийн даалгавар, асуулт хариулт, Таа таа, тунгаа тэмцээнээр өрсөлдөж зохион байгуулагчдын зүгээс бэлтгэсэн даалгавруудыг гүйцэтгэн авхаалж самбаагаа сорьсноос тэргүүн байрт Хилийн цэргийн 0257 дугаар ангийн "Хилчин гоо", дэд байрт Зэвсэгт хүчний 321 дүгээр салбарын "Тэнгэрлэг бүсгүйчүүд", гутгаар байрт Хөвсгөл аймаг дахь Цагдаагийн газрын "Цагаан шонхор" баг тус тус шалгарч мөрдөс нэгт нөхдөө манлайлсан юм.

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗДТГ-ЫН ЦЭРГИЙН ШТАБ**